



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны 02 дугаар сарын 27-ны өдөр

АГУУЛГА

Нэг. Зам, тээврийн хөгжлийн яамны 2022 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын товч тайлан

Хоёр. Хавсралтууд:

1. Шинэ сэргэлтийн бодлогын 2022 оны хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /23 хуудас/;
2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээний тайлан /6 хуудас/
3. Зам, тээврийн салбарын 2022 оны статистик мэдээлэл /76 хуудас/

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн журмын дагуу холбогдох байгууллагуудад хүргүүлсэн тайлангуудын жагсаалт:

1. Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050” хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /2022.11.25-ны өдрийн 01/5445 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн/;
2. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /2022.11.25-ны өдрийн 01/5445 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн/
3. 2022 оны Үндсэн чиглэлийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /2022.12.30-ны өдрийн 01/6091 тоот албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн/
4. Монгол улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /2022.12.30-ны өдрийн 01/6091 тоот албан бичгээр Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлсэн/
5. Шинэ сэргэлтийн бодлогын 2022 оны хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /2022.11.25-ны өдрийн 01/5445 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн/
6. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт /2023.02.14-ний өдрийн 02/713 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн/
7. Гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /2023.02.17-ны өдрийн 01/834 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн/
8. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ /2023.01.24-ний өдрийн 10/355 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн/
9. ЗТХЯ-ны 2022 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /2022.01.31-ний өдрийн 01/500 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн/
10. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн биелэлт /2022.03.01-ний өдрийн 03/899 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн/
11. ЗТХЯ-ны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /2023.28.28-ны өдрийн 01/856 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн/
12. Зам, тээврийн хөгжлийн сайд, аймгуудын Засаг дарга нарын 2022 оны хамтын ажиллагааны гэрээ, Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллахаар байгуулсан “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /2023.01.31-ний өдрийн 01/472 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн/

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн дотооддоо байнгын хяналт тавин ажилласан тайлангуудын жагсаалт:



- 1. Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт*
- 2. ТНБД-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт*
- 3. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний хэрэгжилт*
- 4. Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний хэрэгжилт*
- 5. Сайдын зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн хэрэгжилт*



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2023.02.27

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго:

Зам, тээврийн хөгжлийн яам /цаашид яам гэх/-ны 2022 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгов.

Хоёр. Танилцуулга:

Тайлант хугацаанд яамны 2022 оны үйл ажиллагааг яамны гүйцэтгэлийн төлөвлөгөө, “Алсын хараа 2050” бодлогын баримт бичиг, Шинэ сэргэлтийн бодлого, Засгийн газрын 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2022 оны Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө, Зам, тээврийн салбарт хэрэгжиж буй гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгавар, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөө, Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөө, Сайдын зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэр, Аймаг, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан Санамж бичиг, гэрээ, Мэдээллийн ил тод байдал, Шилэн дансны хөтлөлт, яамны нэгж, харьяа байгууллагуудын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө зэрэг бодлогын бичиг баримт, төлөвлөгөө, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврууд зэрэг 20 үзүүлэлтээр байнгын хяналт тавин улирал, хагас жил, бүтэн жилийн байдлаар давхардсан тоогоор 110 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал, зөвлөмж гарган ажилласан.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам”-д заасан тайлангуудыг яамны газар, хэлтэс, харьяа агентлаг байгууллагуудаас нэгтгэн авч хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт журамд заасан хугацаанд тухай бүр ЗГХЭГ, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яаманд тайлагнаж ажилласан. Мөн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг яамны нэгж, харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд улирал хагас жил, жилийн эцсийн байдлаар дүгнэх үзүүлэлт болгон ашигласан. Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. Яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилт:

Яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 134 арга хэмжээнээс бүрэн хэрэгжсэн 52 арга хэмжээ, 90 хувийн 44, 70 хувийн 18, 50 хувийн 5, 30 хувийн 10, хугацаа болоогүй буюу үнэлгээнд тооцоогүй 5 арга хэмжээний хэрэгжилт **85.0** хувь байна. Үүнээс хариуцсан нэгж, хэрэгжүүлэх үндсэн чиг үүргээр нь авч үзвэл:

/Хүснэгт /

№	Нэгж	Нийт	Үнэлгээ /хувиар/						Үнэлгээнд тооцоогүй	Хэрэгжилт /хувиар/
			100	90	70	50	30	0		
1	БТГ	27	13	6	5	1	2	-	-	85.2
2	ТЗУГ	14	7	4	2	-	-	-	1	92.3
3	АЗБХЗГ	39	20	10	3	-	4	-	2	87.3
4	ИНБХЗГ	13	2	4	4	1	1	-	1	76.7
5	АТБХЗГ	10	3	2	2	3	-	-	-	77.0
6	ТЗДТБХЗГ	19	3	10	2	-	3	-	1	79.4
7	ХШҮДАГ	12	4	8	-	-	-	-	-	93.3
Нийт		134	52	44	18	5	10	-	5	85.04

Яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тендер сонгон шалгаруулалт амжилтгүй болсон 3, санхүүжилт хасагдаж, зорилтод түвшинд хүрэх боломжгүй 2 нийт 5 арга хэмжээг үнэлгээнд тооцоогүй болно. Эдгээрийг дурдвал:

1.5.1. “Дорнод аймгийн Чойбалсан хотыг Хавиргын боомттой холбох 124.5 км хатуу хучилттай авто зам барилгын ажлыг эхлүүлнэ”-Санхүүжилт хасагдсан, тендер 3 удаа зарласан ч амжилтгүй болсон;

1.5.2. “Дорнод аймгийн Баян-Уул сумаас Ульхан боомт хүртэлх 50 км хатуу хучилттай авто зам барилгын ажлыг эхлүүлнэ”- 5 удаа тендер зарлаж, амжилтгүй болсон. Захиалагчаас дахин зарлах зөвшөөрөл хүлээж байна;

1.13.2 “Орон нутгийн нисэх буудлын аэродромд их засвар хийнэ”-Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу хүчингүй болсон;

3.5.4 “Усан замын тээврийн тээврийн дэд бүтцийг хөгжүүлнэ”-Тендер сонгон шалгаруулалт амжилтгүй болсон;

3.8.3 Зам, тээврийн салбарын удирдах ажилтнуудын зөвлөгөөн зохион байгуулна-Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор энэ арга хэмжээ хэрэгжих боломжгүй болсон.

Хэрэгжилт хангалтгүй 30%-тай байгаа 10 арга хэмжээ:

- 1.1.2 “Гашуунсухайт өртөөнөөс Улсын хилийн шугам хүртэлх 7.9 км төмөр замын барилгын ажлыг үргэлжлүүлнэ” /ТЗДТБХЗГ, 1-4 улирал/;
- 1.1.6. “Хөөт-Чойбалсан чиглэлийн 192 км төмөр замын төслийг эхлүүлнэ” /ТЗДТБХЗГ, 1-4 улирал/;
- 1.1.7. “Хөөт-Бичигт чиглэлийн 234.1 км төмөр замын төслийг эхлүүлнэ” /ТЗДТБХЗГ, 1-4 улирал/;
- 1.5.8 “Сүхбаатар аймгийн Баруун-Урт-Бичигт чиглэлийн 272 км, хатуу хучилттай авто зам барих бэлтгэл ажлыг хангана.” /АЗБХЗГ, 1-4 улирал/;
- 1.6.6 “Багануур хотоос Төв аймгийн Мөнгөнморьт сум хүртэл 60 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг үргэлжлүүлнэ” /АЗБХЗГ, 1-4 улирал/;
- 1.6.9 “Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 31.08 км зам авто замын барилгын ажлыг эхлүүлнэ” /АЗБХЗГ, 1-4 улирал/;
- 1.6.10 “Ховд-Өлгий чиглэлийн авто замаас Эрдэнэбүрэн сум чиглэлийн 19.776 км авто замын барилгын ажлыг эхлүүлнэ” /АЗБХЗГ, 1-4 улирал/;
- 1.13.1. “Орон нутгийн нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн хүчитгэн 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ” /ИНБХЗГ, 3-4 улирал/;
- 2.5.6 “Яамны өр, авлагыг бууруулах арга хэмжээ авна” /БТГ, 4 улирал/;
- 3.1.8 “Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төсөл”-ийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангана” /БТГ, 1-4 улирал/

ЗТХЯ-ны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг жилийн эцсийн байдлаар гарган, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт 2023.01.31-ний өдрийн 01/500 тоот албан бичигээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.

2.2. “Алсын хараа-2050” МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт:

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод Зам, тээврийн хөгжлийн сайдын хэрэгжүүлэх 3 зорилго, 5 зорилт, 13 арга хэмжээ тусгагдсан. Зам, тээврийн хөгжлийн сайдын хэрэгжүүлэх 13 арга хэмжээний биелэлтийг 2022 оны жилийн эцсийн байдлаар үнэлэхэд хэрэгжилт **76.15** хувьтай байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын хэрэгжүүлэх 13 арга хэмжээний хэрэгжилтийг авч үзвэл 2022 оны жилийн эцсийн байдлаар 100 хувийн хэрэгжилттэй 6, 70 хувийн хэрэгжилттэй 4, 50 хувийн хэрэгжилттэй 1, 30 хувийн хэрэгжилттэй 2 арга хэмжээ байна. 30 хувийн хэрэгжилттэй дараах 2 арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

№	Арга хэмжээ	Хэрэгжилт	Үнэлгээ
1	Шинэ нийслэл болон Дорнод, Өмнөговь, Ховд, Увс, Завхан, Хөвсгөл аймгуудыг 4С зэрэглэлийн агаарын хөлөг хүлээн авах хүчин чадалтай аэродром, зорчигч үйлчилгээний цогцолбор бүхий олон улсын нисэх буудалтай болгоно.	ЗГ-ын 2020 оны 134 дүгээр тогтоолын дагуу “Чингис хаан” ОУНБ-ын /УБХОУНОШБ/ үйл ажиллагааг 2021.07.04-ний өдрөөс эхлүүлсэн Дорнод, Өмнөговь, Ховд, Увс, Завхан, Хөвсгөл аймгуудын нисэх буудлуудын хөрөнгө оруулалт шийдвэрлэгдээгүй. “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх төслүүдийн талаар Засгийн газрын хуралдааны шийдвэрийн төсөлд тусгах санал, холбогдох мэдээллийг тус яамнаас 2022.05.05-ны өдрийн 01/2091 тоотойр ЭЗХЯ-нд хүргүүлэв. (2022.05.19-ний өдрийн 03/2294)	30
2	Хөшигийн хөндий, Говьсүмбэрийн Баянталд эдийн засгийн чөлөөт бүс, карго логистикийн төв байгуулна.	2021 оны 2 дугаар сард БНСУ-ын Сангийн яам, КОТРА олон улсын байгууллагын Мэдлэг хуваалцах хөтөлбөрийн хүрээнд “Монгол Улсын тээвэр, логистикийн үр ашгийг нэмэгдүүлэх стратеги боловсруулах” техникийн тусалцааны төслийг эхлүүлсэн. Алтанбулагийн логистикийн төв байгуулах ТЭЗҮ боловсруулж байна. Мөн Дэлхийн банк, Сангийн яамтай хамтран “Монгол Улсын тээврийн холболт ба логистикийн төлөвлөлтийг сайжруулах” төслийг хэрэгжүүлж байна. Үүний хүрээнд Увс, Төв, Завхан аймгуудад хөдөө аж ахуйн логистикийн төв байгуулах, орон нутгийн авто замын засвар шинэчлэлтийн ажлыг хэрэгжүүлнэ. Говьсүмбэр аймгийн Баянтал суманд эдийн засгийн чөлөөт бүс байгуулах асуудал Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах тул ажлын албанаас хэрэгжилтийн мэдээлэл гарна.	30

Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050” хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан 2022.11.25-ны өдрийн 01/5445 тоот албан бичигээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.

2.3. МУ-ын ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт:

Засгийн газрын 2021 оны 203 дугаар тогтоолоор баталсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Зам, тээврийн хөгжлийн сайдын хариуцан хэрэгжүүлэх 96 арга хэмжээ тусгагдсан. Үүнээс Зам, тээврийн хөгжлийн



сайдын 2021-2022 онд хэрэгжүүлэх 80 арга хэмжээний биелэлтийг жилийн эцсийн байдлаар үнэллээ. Хэрэгжилт дунджаар **75.7** хувьтай байна.

Төлөвлөгөөнд туссан арга хэмжээг яамны газар, хэлтэс, байгууллагын хариуцсан асуудал тус бүрээр авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

№	Газар, байгууллага	Арга хэмжээ	Арга хэмжээ														Хувь	
			100	90	70	50	30	Санхүүжилтгүй	90.2	89	82	81.2	75	60	60.3	51		49.5
Яамны газар, хэлтэс																		
1.	ТЗДТБХЗГ	12	7	-	3	-	2	-	-	-	-	-	-	-	-	-	80.8	
2.	АЗБХЗГ	46	16	1	-	-	6	14	1	1	1	1	1	2	1	-	1	78.7
3.	АТБХЗГ	5	1	-	3	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	72.0
4.	ИНБХЗГ	15	3	-	3	2	4	2	-	-	-	-	-	-	-	1	-	60.1
5.	БТГ	12	4	1	2	-	2	3	-	-	-	-	-	-	-	-	-	76.7
6.	ТЗУГ	1	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	100.0
Яамны харьяа байгууллага																		
1.	ИНЕГ	14	2	-	3	2	5	2	-	-	-	-	-	-	-	1	-	56.7
2.	"МТЗ" ТӨХК	5	3	-	1	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	80.0
3.	"УБТЗ" ХНН	4	3	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	92.3
4.	"Тавантолгой ТЗ" ХХК	1	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	100.0
5.	"Зүүнбаян ТЗ" ХХК	1	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	100.0
6.	ГТХЗНТөв	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	30.0
7.	"ЗТХТ" ТӨҮГазар	32	14	1	-	-	4	10	-	-	-	1	-	-	1	-	1	81.8
8.	"АТҮТ" ТӨҮГазар	4	1	-	2	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	72.5
	Нийт	80	29	2	8	3	12	16	1	1	1	1	1	2	1	1	1	75.7

Хөтөлбөрийн хэрэгжилтэд 0-30 хүртэл хувийн биелэлттэй 12 арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэллээ. Үүнд:

- Дорноговь аймгийн Сайншанд - Баруун-Урт - Хөөт чиглэлийн 433 км төмөр замын төслийг эхлүүлнэ;
- Төмөр замын хөдөлгөөний нэгдсэн удирдлагын төвийн барилга барих төсөл;
- Дархан-Алтанбулаг чиглэлийн 113 км авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчилнэ;
- Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Овоотын уурхайгаас Арцсуурь хилийн боомт хүртэлх авто замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулна;
- Ховд-Улаангом чиглэлийн 163.3 км хатуу хучилттай авто замыг барих /Ховд, Увс аймаг/;
- Олон улс, улсын чанартай авто замын төлбөр авах цэгийг цахимжуулах, Мөрөн, Чойр, Даланзадгад, Түмэнцогт, Хяргас нуур орчимд төлбөр авах цэг байгуулна;
- Олон улс, улсын чанартай авто зам дээр одоо байгаа төлбөр авах цэгт төлбөрийн цахим систем нэвтрүүлнэ;
- Чойр, Даланзадгад, Түмэнцогт, Хяргас нуур орчимд төлбөр авах цэг байгуулна;
- Дорнод аймгийн Чойбалсан нисэх буудлыг 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ;

- Ховд аймгийн "Ховд" нисэх буудлыг 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ;
- Хөвсгөл аймгийн "Мөрөн" нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн хүчитгэж олон улсын 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ;
- Увс аймгийн "Дээлий цагаан" нисэх буудлын хөөрч буух зурвасын хүчин чадлыг олон улсын 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасны дагуу 2022.11.25-ны өдрийн 01/5445 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.

2.4. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэлийн хэрэгжилт:

"Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам"-ын дагуу зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан зорилтыг хэрэгжүүлэх 16 арга хэмжээний хэрэгжилтийг 2022 оны жилийн эцсийн байдлаар авч үзвэл дунджаар 93.1 хувийн биелэлттэй, Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилт 86.4 хувийн биелэлттэй, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт 79.4 хувийн биелэлттэй, Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний хэрэгжилт 87.1 хувийн биелэлттэй, Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний хэрэгжилт 85.8 хувийн биелэлттэй тус тус үнэлэгдлээ.

№	ГАЗАР, ХЭЛТЭС	Нийт заалт	100	90	70	50	30	94.7	87	80	69	63.6	62	47	32.8	22.8	Хугацаа боловчлох	Хувь
1	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	16	10	5	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	93.1
2	Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр	20	12	-	-	-	-	-	1	1	1	1	1	1	1	-	1	86.4
3	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт	4	2	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	1	-	79.4
4	Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт	30	13	-	1	1	2	-	-	-	-	-	-	-	-	-	13	87.1

5	Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт	30	16	1	3	2	2	-	-	-	-	-	-	-	-	6	85.8
Нийт		100	53	6	4	3	5	1	1	1	1	1	1	1	1	20	87.2

1. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 30 хувийн биелэлттэй дараах 8 арга хэмжээг үр дүнгүй гэж үнэллээ. Үүнд:

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл:

- 4.2.15. Арц суурь боомтыг Нөмрөг сумтай, Улиастай хотыг Алтай хоттой холбосон автозамуудыг барина. /Хэрэгжилт 30 хувь/

Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр

- Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто зам /Хэрэгжилт 47 хувь/
- Багануур-Мөнгөнморьт чиглэлийн хатуу хучилттай 60 км авто зам /Хэрэгжилт 32.8 хувь/

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт

- Шинээр баригдах улсын чанартай авто замын урт 2022 км /Хэрэгжилт 22.84 хувь/
- **Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээ**
- Хэнтий аймгийн Жаргалтхаан сум-Өмнөдэлгэр сум-Рашаан хад-Өглөгчийн хэрэм-Биндэр сум-Баян-Адарга сум-Дадал сум чиглэлийн 290 км хатуу хучилттай автозам төсөл /Хэрэгжилт 30 хувь/
- Булган аймгийн Гурванбулаг-Хишиг-Өндөр-Орхон чиглэлийн 99.7 км хатуу хучилттай авто зам /Хэрэгжилт 30 хувь/
- **Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээ**
- Хөвсгөл аймгийн Мөрөн нисэх буудлыг 4С ангиллын олон улсын нисэх буудал болгох /ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, хэрэгжилт 30 хувь/
- Зүүн босоо чиглэлийн төмөр зам /ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, хэрэгжилт 30 хувь

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу 2022.12.30-ны өдрийн 01/6091 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.

2.5. Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт:

Улсын Их Хурлын 2021 оны 56 дугаар тогтоолоор “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө батлах тухай” баталсан. Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан 3 зорилтыг хэрэгжүүлэх нийт 38 арга хэмжээний хэрэгжилт байна. Үүнд:

- Авто замын салбарт 1 зорилтыг хэрэгжүүлэх 19 арга хэмжээ

- Төмөр зам, далайн тээврийн салбарт 1 зорилтыг хэрэгжүүлэх 7 арга хэмжээ
- Иргэний нисэхийн салбарт 1 зорилтыг хэрэгжүүлэх 6 арга хэмжээ
- Автотээврийн салбарт 1 зорилтыг хэрэгжүүлэх 6 арга хэмжээ

Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 38 арга хэмжээний хэрэгжилтийг 2022 оны жилийн эцсийн байдлаар авч үзвэл дунджаар **76.8** хувийн биелэлттэй үнэлэгдлээ. Хэрэгжилтийг давхардсан тоогоор газар, хэлтэс тус бүрээр авч үзвэл:

№	Газар, харьяа байгууллага	Нийт	100	90	70	50	30	88.6	76.8	72	60	Хэрэгжих боломжгүй	Хувь
1	АЗБХЗГ	18	6	1	1	1	1	-	1	1	1	5	80.7
2	“ЗТХТ” ТӨҮГ	9	5	-	1	1	-	-	1	-	-	1	87.2
3	ИНБХЗГ, ИНЕГ	6	3	-	-	-	3	-	-	-	-	-	65.0
4	АТБХЗГ	5	3	-	1	1	-	-	-	-	-	-	84.0
5	“АТҮТ” ТӨҮГ	1	-	-	1	-	-	-	-	-	-	-	70.0
6	ТЗДТБХЗГ	7	4	-	-	1	1	1	-	-	-	-	89.8
7	“УБТЗ” ХНН	2	1	-	-	-	-	1	-	-	-	-	94.3
8	“МТЗ” ТӨХК	2	2	-	-	-	-	-	-	-	-	-	100.0
9	ГТХЗТ	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	50.0
10	Тавантолгой ТЗ	1	1	-	-	-	-	-	-	-	-	-	100.0
11	БТГ	8	1	-	-	-	3	-	-	-	-	4	47.5
Нийт		38	16	1	2	3	6	1	1	1	1	6	76.8

Төлөвлөгөөний хэрэгжилтэд 30 хүртэл хувийн биелэлттэй 6 арга хэмжээ:

- 3.6.12 Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлэх;
- 3.6.31 Ховд-Улаангом чиглэлийн 163.3 км хатуу хучилттай авто замыг барих;
- 3.6.32 Дорнод аймгийн “Чойбалсан” нисэх буудлыг олон улсын 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлэх;
- 3.6.33 Ховд аймгийн “Ховд” нисэх буудлыг олон улсын 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлэх;
- 3.6.34 Хөвсгөл аймгийн “Мөрөн” нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн хүчитгэж, олон улсын 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлэх;
- 6.1.10 Улаанбаатар хотод олон улсын логистикийн төв байгуулах.

Төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээнд тооцогдоогүй 6 арга хэмжээ:

- 3.6.9 Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийг замыг Мөрөн-Тариалан чиглэлийн авто замтай холбох 112.7 км хатуу хучилттай авто замыг эхлүүлнэ;
- 3.6.23 Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс “Цагаандэл уул” хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто замыг барих;
- 3.6.24 Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн 124.5 км хатуу хучилттай авто замыг барих ажлыг эхлүүлэх;
- 3.6.25 Хэнтий аймгийн Норовлин-Дорнод аймгийн Баян-Уул-Ульхан боомт чиглэлийн 124 км хатуу хучилттай авто замыг барих;
- 3.6.29 Сүхбаатар аймгийн Баруун-Урт-Эрдэнэцагаан-Бичигт боомт чиглэлийн тусгай зориулалтын авто замын барилгын ажлыг эхлүүлэх;

- 3.6.30 Арц суурь-Шивээ хүрэн төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу 2022.12.30-ны өдрийн 01/6091 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.

2.6. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилт:

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа 6 төслийн хүрээнд 10 арга хэмжээг хамруулан 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд **71.4** хувийн дундаж хэрэгжилттэй байна. Энэ нь 10.3 хувиар өссөн байна. Дархан - Алтанбулаг чиглэлийн 118 км авто замын засварын ажлын сонгон шалгаруулалтыг 2023 онд хийхээр төлөвлөсөн тул үнэлгээнд тооцоогүй болно.

№	Төслийн нэр	Арга хэмжээний нэр	2022 оны үнэлгээ	Төслийн хэрэгжилт
1. Авто замын салбар				
1	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-2”	Баруун бүсийн босоо тэнхлэгийн АН-4 чиглэлийн авто замын трассын дагуу баригдах 189.7 км хатуу хучилттай авто зам (Багц CW1-1, Багц CW1-2, Багц CW1-3, CW1-4 хэсгүүд)	95 хувь	96.5 хувь
2	БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл	“Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто зам”	100 хувь	100 хувь
3	Монгол Улсын Засгийн газар болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулсан “Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын өргөтгөлийн төсөл”	Улаанбаатар-Дархан чиглэлийн 202,42 км авто замын шинээр баригдах өргөтгөлийн төсөл	65 хувь	60,5 хувь
4	Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжиж буй “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл”	Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замын өргөтгөл шинэчлэлтийн ажил	84,9 хувь	83 хувь
		Дархан-Алтанбулаг чиглэлийн 118 км авто замын аюулгүй байдлыг хангах засвар, арчлалтын ажил	-	-
		Хүйтний хөндий-Арвайхээр чиглэлийн 58 км авто замын их засвар	100 хувь	85.8 хувь
2. Төмөр замын салбар				
5	“Монгол Улсын төмөр замын хөгжлийн стратеги Зүүн Азийн Төмөр замын нийгэмлэг (EARC)-ийн үүсгэн байгуулалттай уялдах нь” төсөл		30 хувь	30 хувь (Судалгааны ажил үргэлжилж байна).



	MON TA 8935: Богдхан тойруу төмөр замын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй Богдхан төмөр зам төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа боловсруулах зөвлөх үйлчилгээний төсөл	Франц Улсын “Систра” компани болон Монгол Улсын “Эм Си Пи, Си Жи Ар” компанийн нэгдлээс төслийн Англи, Монгол хэл дээрх эцсийн шатны тайлан боловсруулах.	100 хувь	100 хувь
	“Монгол Улсын Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв (ГТХЗНТ)-ийн барилга барих, түүний үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх замаар Монгол Улсын төмөр замын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх” төсөл		30 хувь	30 хувь (БНСУ-ын Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага, Зам, тээврийн хөгжлийн яам, “Эм Эс Эл” ХХК, “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ хамтарсан гэрээ байгуулсан).
3. Иргэний нисэхийн салбар				
6	Хэнтий аймгийн “Өндөрхаан нисэх буудлыг шинэчлэн барих төсөл”	Багц-1 барилга байгууламжийн ажил, Багц-2 аэродромын ажил гүйцэтгэх	38 хувь	66 хувь
4. Авто тээврийн салбарт: Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр тус салбарт 2022 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээ байхгүй.				
Дундаж үнэлгээ			71.4 хувь	72.4 хувь

Зам, тээврийн салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслүүдийн хэрэгжилтийг хяналт-шинжилгээ-үнэлгээний тайлангийн хамт Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу 2023.02.17-ны өдрийн 01/834 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.

2.7. Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

2022 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын 9 хуулийн 77 заалт, Улсын Их Хурлын 4 тогтоолын 8 заалт, Ерөнхийлөгчийн 5 зарлигийн 7 заалт, Улсын Их Хурлын Байнгын хорооны 2 тогтоолын 2 заалт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2 зөвлөмжийн 2 заалт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 1 хуралдааны 4 заалт, Засгийн газрын 24 тогтоолын 39 заалт, Ерөнхий сайдын 1 захирамжийн 1 заалт, Засгийн газрын хуралдааны 36 тэмдэглэлийн 75 заалт, Засгийн газрын 5 албан даалгаврын 6 заалт буюу нийт 89 шийдвэрийн 214 заалтыг хяналтад авч, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

	Үүнээс
--	---------------

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр		Бүгд	Монгол Улсын хууль	Улсын Их Хурлын тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	УИХ-ын Байнгын хорооны тогтоол	ҮАБЗ-ийн зөвлөмж	ҮАБЗ-ийн хуралдааны	Засгийн газрын тогтоол	Ерөнхий сайдын захирамж	Засгийн газрын албан даалгавар	Засгийн газрын хуралдааны
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо		89	9	4	5	2	2	1	24	1	5	36
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо		214	70	8	7	2	2	4	39	1	6	75
Үүнээс	Биелсэн 100	125	46	3	7	1	2	3	15	1	3	44
	Хэрэгжих шатанд	68	10	5	-	1	-	-	20	-	3	29
	70 хувь	51	2	2	-	1	-	1	156	-	3	25
	30 хувь	18	8	2	-	-	-	-	4	-	-	4
	Хугацаа болоогүй	20	14	-	-	-	-	-	4	-	-	2
	Тасарсан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Биелэлтийн дүн /хувь/		85.6	88.9	71.3	100.0	85.0	100.0	92.5	78.3	100	85.0	85.9

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд бүрэн хэрэгжсэн 125, хэрэгжих шатанд буюу 70 хувийн хэрэгжилттэй 51, хэрэгжилт хангалтгүй 30 хувийн хэрэгжилттэй 18 арга хэмжээ, хугацаа болоогүй 20 арга хэмжээний дундаж үнэлгээ 85.6 хувиар үнэлэгдлээ.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хариуцсан нэгж, хэрэгжүүлэх харьяа байгууллагаар авч үзвэл:

№	Газрын нэрс	Нийт заалт	Үүнээс /хувиар/					Хүчингүй болсон	Хяналтаас хасагдсан	Биелэлт хувь
			100	70	30	0	Хугацаа болоогүй			
1	БТГ	42	19	15	4	-	4	-	-	80.8
2	ТЗУГ	34	23	7	-	-	4	-	-	93.0
3	ХШУДАГ	11	6	5	-	-	-	-	-	86.4
4	АЗБХЗГ	47	22	14	5	2	4	2	2	77.4
5	АТБХЗГ	26	12	10	2	-	2	-	-	81.7
6	ТЗДТБХЗГ	65	26	25	11	-	3	-	-	75.5
7	ИНБХЗГ	22	7	12	2	-	1	-	-	76.2
8	ИНЕГ	6	2	2	1	-	1	-	-	74.0
9	СХГ	1	-	-	-	-	1	-	-	-
10	ЗТХТ	3	-	1	1	-	1	-	-	50.0
11	АТҮТ	3	-	1	1	-	1	-	-	50.0
12	ГТХЗНТ	3	1	1	-	-	1	-	-	85.0
13	МИАТ	3	1	1	-	-	1	-	-	85.0
14	УБТЗ	4	2	1	-	-	1	-	-	90.0
15	МТЗ	10	1	6	2	-	1	-	-	64.4
16	ТТЗ	4	3	1	-	-	-	-	-	92.5
17	Далайн захиргаа	9	-	-	4	3	2	3	3	17.1
18	ХХНОБ	4	-	2	1	-	1	-	-	56.7
19	НТОЗШША	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт		214	125	51	18	0	20	2	3	85.6

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хяналт-шинжилгээ-үнэлгээний тайлангийн хамт Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоолоор баталсан

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу 2023.02.14-ны өдрийн 03/266 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.

2.8. Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Тайлант хугацаанд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2015-2022 оны нийт 426 тушаалын 843 /давхардсан тоогоор/ үүрэг даалгаврын хэрэгжилтийг хяналтад авч, 2022 оны жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжсэн 285, 70 хувийн хэрэгжилттэй 72, 30 хувийн хэрэгжилттэй 10, тасарсан буюу 0 хувийн хэрэгжилттэй 1, хугацаа болоогүй 51, болсон хүчингүй болсон 17 үүрэг даалгаврын хэрэгжилт **91.9** хувьтай байна.

Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хариуцан хэрэгжүүлэх байгууллага, газар тус бүрээр нь үзүүлвэл:

№	Хэрэгжүүлэгч	Нийт заалт	Үүнээс /хувиар/					Хүчингүй болсон	Биелэлт хувь
			100	70	30	хэрэгжээгүй, биелэлт ирүүлээгүй	Хугацаа болоогүй		
1	Дэд сайд	11	3	4	1	-	2	1	76.2
2	ТНБД	31	15	7	-	-	8	1	90.4
3	БТГ	51	33	11	-	-	5	2	92.5
4	ТЗУГ	22	18	-	-	-	4	-	100.0
5	ХШУДАГ	60	39	8	-	-	11	2	94.8
6	АЗБХЗГ	53	33	12	1	-	6	1	90.6
7	АТБХЗГ	43	26	11	1	-	3	2	89.4
8	ТЗДТБХЗГ	33	19	5	3	1	4	1	83.5
9	ИНБХЗГ	55	46	6	1	-	1	1	95.2
10	ИНЕГ	128	85	22	5	-	16	-	90.9
11	ЗТХТ	61	33	8	8	3	9	-	78.8
12	АТҮТ	80	55	20	2	-	2	1	90.3
13	ГТХЗНТ	52	38	5	2	-	6	-	91.5
14	МИАТ	45	41	2	-	-	2	-	98.6
15	УБТЗ	49	45	2	-	-	2	-	98.7
16	МТЗ	54	41	7	1	-	5	-	94.2
17	Далайн захиргаа	50	32	5	3	1	9	-	88.7
18	НТОЗШША	6	3	-	-	-	3	-	100.0
19	төслийн нэгж	1	1	-	-	-	-	-	100.0
20	ХХНОБ	22	19	1	-	-	2	-	98.5
НИЙТ		843	588	124	27	6	88	10	91.6
		436	285	72	10	1	51	17	91.9

2.9. Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 3, 2016 оны 1, 2017 оны 8, 2018 оны 4, 2019 оны 11, 2020 оны 20, 2021-2022 оны 97 нийт 144 тушаалын 147 заалтын хэрэгжилтийг хяналтад авч ажиллалаа.

Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн хэрэгжилтийн байдалд 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд бүрэн хэрэгжсэн 122, 70 хувийн хэрэгжилттэй 10, хэрэгжилт ирүүлээгүй 0 хувийн 1, хугацаа болоогүй 11 үүрэг даалгаврын хэрэгжилт **97.2** хувьтай байна. Үүрэг даалгаврын биелэлтийг хариуцан хэрэгжүүлэх байгууллага, газар тус бүрээр нь үзүүлвэл:

№	Газрын нэрс	Нийт заалт	Үүнээс /хувиар/				Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	Биелэлт хувь
			100	70	30	хэрэгжээгүй, биелэлт ирүүлээгүй			
1	БТГ	11	8	2	-	-	1	-	96.7
2	ТЗУГ	11	7	2	-	-	2	-	93.3
3	ХШУДАГ	49	44	1	-	-	4	-	99.3
4	АЗБХЗГ	38	31	3	-	1	3	-	94.6
5	АТБХЗГ	1	1	-	-	-	-	-	100.0
6	ТЗДТБХЗГ	27	26	1	-	-	-	-	98.9
7	ИНБХЗГ	3	2	1	-	-	-	-	90.0
8	ИНЕГ	2	1	-	-	-	1	-	100.0
9	ЗТХТ	1	1	-	-	-	-	-	100.0
10	УБТЗ	1	1	-	-	-	-	-	100.0
НИЙТ		144	122	10	-	1	11	-	97.2
НИЙТ		147	124	11	-	1	10	1	96.8

2.10. Засгийн газрын хуралдаанаар 2022 онд хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний хэрэгжилт:

Засгийн газрын хуралдаанаар 2022 оны 17 асуудал хэлэлцүүлэхээр төлөвлөж, хэлэлцүүлсэн 11 арга хэмжээ, хэлэлцүүлэхээр холбогдох материалыг хүргүүлсэн ба хуралдааны тов хүлээж буй 70 хувийн 4, тасарсан буюу 0 хувийн 1, хэлэлцүүлэх шаардлагагүй болсон 1 арга хэмжээнүүдийн дундаж үнэлгээ **86.2** хувьтай байна. Яамны нэгжүүдийн үнэлгээг тус бүрээр авч үзвэл:

№	Нэгжүүд	Нийт арга хэмжээ	Үнэлгээ /хувиар/				Хэлэлцүүлэх шаардлагагүй	Үнэлгээ /хувиар/
			100	70	30	0		
1	АТБХЗГ	3	1	-	-	1	1	50.0
2	АЗБХЗГ	1	1	-	-	-	-	100.0
3	БТГ	1	1	-	-	-	-	100.0
4	ИНБХЗГ	6	2	4	-	-	-	80.0
5	ТЗДТБХЗГ	6	6	-	-	-	-	100.0
Нийт		17	11	4	-	1	1	86.2

2022 оны байдлаар 0 хувийн болон Засгийн газраар хэлэлцүүлэх шаардлагагүй болсон асуудлуудыг үзүүлвэл:

№	Хэлэлцүүлэх асуудал	Хугацаа	Хариуцах нэгж	Хамтран хэрэгжүүлэх нэгж	Хэрэгжилт
0 хувийн хэрэгжилттэй					
1	Тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл, ашиглалтын аюулгүй байдлын техникийн зохицуулалтын төсөл	2022-09-28	АТБХЗГ	БТГ	Тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл, ашиглалтын аюулгүй байдлын техникийн зохицуулалтыг боловсруулсан бөгөөд холбогдох газруудаас саналыг авахаар хүргүүлээд байна.
Хэлэлцүүлэх шаардлагагүй болсон					

2	“Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1998 оны 05 дугаар тогтоолд нэмэлт оруулах хуулийн төсөл	2022-08-24	АТБХЗГ	-	Уг асуудлыг /баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл/ Автотээврийн тухай хуулиар зохицуулахаар хуулийн төсөлд тусгасан бөгөөд Хуулийн төслийг намрын чуулганаар хэлэлцүүлэхээр бэлдэж байна. Намрын чуулганы жагсаалтад тусгагдсан.
---	--	------------	--------	---	---

2.11. Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний хэрэгжилт:

Сайдын зөвлөлийн хуралдаанаар 2022 онд 27 асуудал хэлэлцүүлэхээр төлөвлөж, жилийн эцсийн байдлаар төлөвлөсөн хугацаандаа хэлэлцүүлсэн 6, холбогдох материалыг хүргүүлж, хуралдааны товыг хүлээж буй 8, хэлэлцүүлэх шаардлагагүй болсон 13 асуудлын дундаж үнэлгээ 100.0 хувь байна.

Тайлант хугацаанд цаг үеийн шаардлагаар нэмэлтээр 3 асуудал хэлэлцүүлсэн байна. Сайдын зөвлөлийн хуралдаанаар 2022 онд хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний хэрэгжилтийг доорх хүснэгтээр үзүүлэв.

№	Хугацаа	Нийт арга хэмжээ	Үнэлгээ /хувиар/					Хэлэлцүүлэх шаардлага -гүй	Материал хүргүүлсэн	Биелэлт /хувиар/
			100	70	30	0				
1	1 улирал	8	5	-	-	-	3	-	100.0	
2	2 улирал	11	1	-	-	-	8	2	100.0	
3	3 улирал	4	-	-	-	-	2	2	-	
4	4 улирал	4	-	-	-	-	-	4	-	
Нийт		27	6	-	-	-	13	8	100.0	
Нэмэлтээр		3	3	-	-	-	-	-	100.0	

Сайдын зөвлөлийн хуралдаанаар 2022 оны жилийн эцсийн байдлаар хариуцсан газраас холбогдох материалыг ТЗУГ-т хүргүүлж, сайдын зөвлөлийн хуралдааны товыг хүлээж буй 8 арга хэмжээг доорх хүснэгтээр үзүүлбэл:

№	Хэлэлцүүлэх асуудал	Хугацаа	Хариуцах газар, хэлтэс	Хэрэгжилт
